



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төсвийн сахилга бат, хариуцлагыг
чангатгах тухай

Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас ДААЛГАХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгов:

1.1.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах;

1.2.төрийн байгууллагын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүгийн төлбөр, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, онцгой байдлын байгууллагын шаардлагатай урсгал зардлыг тэргүүн ээлжид, бусад зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрэмбийн дагуу санхүүжүүлэх;

1.3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх;

1.4.тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах:

1.4.1.хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх;

1.4.2.байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох;

1.4.3.тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх;

1.4.4.гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх;

0025800034

1.4.5.төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх.

2.Уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос нэмэлт орлого төвлөрүүлэх боломжийг судалж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Н.Цэрэнсамбуу)-д тус тус даалгав.

3.Татварын өр төлбөрийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүндрэл үүсгэлгүйгээр, зөвлөн туслах байдлаар барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР